



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 578

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1.Боловсролын зээлийн сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 13 нэрийн, нийт 40,755,455.00 (дөчин сая долоон зуун тавин таван мянга дөрвөн зуун тавин тав) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн
578 дугаар тогтоолын хавсралт

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Принтер	ш	1	5/6/2020	1,320,000.00	1,320,000.00	-
2	Компьютер	ш	10	5/6/2020	2,800,000.00	28,000,000.00	-
3	Дэлгэц	ш	2	5/6/2020	450,000.00	900,000.00	-
4	Нөүтбүүк	ш	2	5/6/2020	2,739,000.00	5,478,000.00	-
5	ONT төхөөрөмж	ш	1	5/6/2020	198,000.00	198,000.00	-
6	Сүлжээний бахь	ш	1	5/6/2020	48,000.00	48,000.00	-
7	Сүлжээ цацагч	ш	2	5/6/2020	150,000.00	300,000.00	-
8	Сүлжээний кабель	ш	1	5/6/2020	71,500.00	71,500.00	-
9	Проекторын хатуу гэр	ш	1	5/6/2020	385,000.00	385,000.00	-
10	агаар цэвэршүүлэгч	ш	1	8/21/2017	650,000.00	650,000.00	-
11	РАМ	ш	13	5/6/2020	62,535.00	812,955.00	-
12	Тог баригч	ш	5	5/6/2020	358,400.00	1,792,000.00	-
13	Ширээ-албан хаагч	ш	1	1/2/2014	800,000.00	800,000.00	-
	НИЙТ ДҮН		41		10,032,435.00	40,755,455.00 (дөчин сая долоон зуун тавин таван мянга дөрвөн зуун тавин тав)	-